



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
БУЯНТОГТОХЫН БАТЗОРИГ ТАНАА**

2020-09-03 № 027-2020/06-НД-НБ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд Сүхбаатар сумаас бие даан нэр дэвшигч Буянтогтохын Батзоригийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд Сүхбаатар сумаас бие даан нэр дэвшигч Б.Батзориг нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050” холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.


## Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Б.Батзоригийн Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Б.Батзоригийн мөрийн хөтөлбөр /.../ хуудас/-ийг хавсаргав.


Хувийг: Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

СЭЛЭНГЭ АЙМГИЙН 2020 ОНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
БУЯНТОГТОХЫН БАТЗОРИГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



1. Сонгогч иргэдийнхээ хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээг эрхэм зорилгоо болгож аймгийн ИТХ-ын бодлого шийдвэрт тусгуулан хэрэгжүүлэхийн төлөө идэвх санаачилга гаргаж ажиллана.
2. Нутаг орныхоо хөгжлийн боломжуудыг бүрэн дүүрэн дайчлан ашиглах талаар санал боловсруулж, аймгийн ИТХ-д оруулж хэлэлцүүлнэ.
3. Хүүхдийн цэцэрлэгийн хүчин чадлыг өргөтгөх талаар холбогдох байгууллагуудад санал тавьж, төсөв хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлнэ.
4. Ерөнхий боловсролын сургуулийн орчны гэрэлтүүлэг, камержуулах асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлүүлж, хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлнэ.
5. Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын талбайг орчин үеийн стандарт шаардлага хангахуйц хэмжээнд тохижуулан сургалт, амралт, чөлөөт цагийн үлгэр жишээ орчныг бий болгох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
6. Багуудын нутаг дэвсгэрт сагсан бөмбөгийн стандартын талбай байгуулах санал, санаачилга гарган хэрэгжүүлж, орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран жил бүр спортын өдөрлөгийг зохион байгуулна.
7. Бага насны хүүхэд тоглох аюулгүй орчин бүхий тоглоомын талбайг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр байгуулах арга хэмжээ авна.
8. Өрхийн эмнэлгүүдийг чадавхжуулах, оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг чанартай үзүүлэх нөхцөл боломжоор хангах асуудлыг ЭМГ-тай хамтран боловсруулж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.
9. Иргэн бүрийг 2 жил тутамд, ахмад настныг жил бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоо шинжилгээнд хамруулах асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
10. Аймгийн нэгдсэн эмнэлгийн уламжлалт анагаах ухааны тасгийн хүчин чадлыг нэмэгдүүлж, үйлчилгээг хүртээмжтэй болгох чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, шийдвэрлэнэ.
11. Багийн нутаг дэвсгэрт 24 цагийн эмийн сан, хүнсний дэлгүүрийн үйлчилгээ бий болгох асуудлыг холбогдох байгууллагуудад санал тавьж, шийдвэрлүүлнэ.
12. Гэр хорооллын айл өрхүүдийг дулаан, цэвэр усны шугам сүлжээнд холбох, бохирын нэгдсэн байгууламжтай болгох асуудлыг улс, орон нутгийн төсөвт суулгуулж, хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана.
13. Айл өрхийн ахуйн хог хаягдлыг ангилж ялган савлуулах технологийг хэрхэн хийх аргыг иргэдэд заан сурталчлах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

14. Байгаль орчныг хамгаалах аймгийн бодлогын баримт бичгийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж, аймгийн ИТХ-аар хурлаар батлуулна.
15. Гэрэлт цогцолбор, Сайханы хөтөл, Орхон Сэлэнгийн бэлчрийн аялал жуулчлалын маршрутын дагуу худалдаа үйлчилгээний цэгүүд ажиллуулах иргэдийн санал санаачилгыг дэмжиж ажиллана.
16. Хүнсний бүтээгдэхүүний чанар стандартад тавих хяналтыг сайжруулан, хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр хангах хөтөлбөрийг шинээр боловсруулж, ИТХ-аар батлуулан хэрэгжүүлнэ.
17. Орон сууцны байруудын СӨХ-дыг чадавхжуулж, үйл ажиллагааг тогтмолжуулан, цахилгаан, сантехникийн дуудлагын үйлчилгээг шуурхай, чанартай болгох талаар холбогдох мэргэжлийн байгууллагуудад асуудал тавьж шийдвэрлүүлнэ.
18. Ахмад настнууд агаар салхинд суух, амрах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зориулалтын сүүдрэвчүүдийг барьж тохижуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтарч хийнэ.
19. Гэр хорооллын гудамжны замыг засаж сайжруулах, гэрэлтүүлэг, камержуулах ажлыг шат дараатайгаар хийж, хэрэгжүүлэх санхүүжилтийг орон нутгийн төсөвт тусгуулж, хэрэгжүүлнэ.
20. Орон сууцны болон гэр хорооллын гудамж талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран, багийн иргэдийн оролцоотойгоор зохион байгуулна.
21. Иргэд сонгогчдын санал хүсэлтийг хүлээн авч сар бүр хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулдаг өдөртэй болно.
22. Аймгийн ИТХ-аар хэлэлцэх асуудлын талаар сонгогч иргэдэд мэдээлэл өгч, тэдний саналыг авч хурлаас гаргах шийдвэрт тусгуулахын төлөө ажиллана.
23. Сонгогдсон тойргийнхоо айл өрхийн амьжиргааны түвшин, ажилгүй иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж өрхийн амьжиргааг дэмжих, халамж үйлчилгээнд хамруулах, ажил хөдөлмөр эрхлүүлэх ажлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.

Бие даан нэр дэвшигч

2020.07.24

Б.Батзориг